

МОНГОЛ УЛС ДАХЬ ЯПОН СУДЛАЛЫН  
БАЙДАЛ, ТӨЛӨВ

Ж. Уянга

Монголчууд Японыг сонирхон судалсан нь бүр XIII зуунаас эхэлсэн билээ. Гэхдээ тэр нь зөвхөн цэрэг дайны зориулалттай судалгаа байв. XX зууны эхээр БНМАУ-д Японыг сонирхон судлах ажил Японыг бодвол бага хэмжээтэй ч гэсэн хийгдэж байсан байна. Энэ нь тухайн үеийн олон улсын ээдрээтэй байдалд үүссэн бас л цэрэг улс төрийн чиглэлтэй судалгаа байв.

1959 онд монголч эрдэмтдийн анхдугаар их хурал Улаанбаатар хотод болсон. Тэр их хуралд Ивамура Шинобу, Хаттори Широ, Абемацу Гэничи, Сакамото Корэтада зэрэг японы нэрт эрдэмтэд ирж оролцож, монгол эрдэмтэн нартай холбоо харилцаа тогтоож ном зохиол харилцан солилцох болсон. Энэ нь Монголд япон судлал үүсэн хөгжихөд их түлхэц нөлөө болсон юм.

1968 онд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэргэд Ази, Африкийн хэлтэс анх байгуулагдсан явдал Ази, Африкийн орнууд, түүний дотор, Япон улсыг судлах ажлыг эрдэм шинжилгээний чиглэлтэй болгоход чухал алхам болсон.

1972 онд Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр орны найрсаг харилцаа тогтвортой хөгжиж, улс төр, худалдаа эдийн засаг, соёл хүмүүнлэгийн зэрэг олон салбарт өргөжиж ирсэн. Монгол дахь япон судлалын ажилд ч ихээхэн ахиц гарсан юм. 1975 оноос Монгол улсын Их сургуульд япон хэлний хичээл зааж эхэлжээ. Олон мянган жилийн түүхтэй япон үндэстний түүх, хэл, соёл, тэрчлэн монгол-японы ард түмний харилцааны түүхэн өв уламжлал, өнөөгийн байдал, хэтийн төлөвийг судлан, япон судлалыг бие даасан судлал болгон хөгжүүлэх нь япон судлаачдын хувьд гол зорилго болсон юм.

Өнгөрсөн хугацаанд Монгол дахь япон судлалын ажил голчлон дараах чиглэлээр явагдаж ирсэн нь ажиглагддаг.

1. Япон улс монгол судлалыг XX зууны эхэн үеэс улс төр, түүх, нийгэм, эдийн засаг, хэл, соёл, утга зохиол, боловсрол гэх мэт судалгааны олон салбарт хөгжүүлж, монгол судлалаар дэлхийд бараг тэргүүн байранд гарч ирсэн билээ. Иймд Япон улсад хийгдэж буй Монгол судлалын ажил, тэнд хэвлэгдэн гарсан манай улсын холбогдолтой ном зохиол зэргийг судлан танилцуулах ажлыг голлон хийжээ.

2. Монгол-Японы харилцааны асуудлаар хийгдсэн ажлууд юм. Сүүлийн үед монгол-японы харилцааг дагнан авч судалсан диссертаци зохиол хэд хэд гарсан. Тухайлбал, Зүүн хойт Ази судлалын төвийн болон Олон улсын харилцааны дээд сургуулийн япон судлаач нар хамтран "Монгол-Японы харилцаа эрт эдүгээ" эмхэтгэл гаргалаа. Мөн доктор Ц.Батбаярын "Монгол ба Япон XX зууны эхэн хагаст" хэмээх эрдэм шинжилгээний зохиол хэвлэгдэн гарлаа.

---

\*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн  
эрдэм шинжилгээний ажилтан

Эдүгээ Монгол орон ардчилал, зах зээлийн замд оржээ. Монгол улсын гадаад бодлого нээлттэй болсон энэ үед Монгол дахь япон судлал олон салбарт, эрчимтэй хөгжиж байна. Манай япон хэлний сургалттай бага дунд сургууль, их дээд сургуулиудад япон хэлийг сонирхон суралцах оюутан, сурагчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Судалгаагаар, арав гаруй бага дунд сургууль ба их дээд сургуульд япон хэлний хичээл зааж байна. Нийлээд 50 гаруй япон хэлний багш ажиллаж байна. Мөн жилд ойролцоогоор 8000 гаруй оюутан сурагчид япон хэл суралцаж байна гэсэн тоо гарчээ.

Хоёр орон харилцан бие биеэ ойлголцоход соёл, урлаг, шинжлэх ухааны өргөн хамтын ажиллагаа ихээхэн үр дүн үзүүлсэн юм. Багш, оюутан, мэргэжил дээшлүүлэгчдийн солилцоо улам өргөжиж, соёлын хамтын ажиллагааны дагуу японы их дээд сургууль, коллежуудад манай оюутнууд олноор суралцаж байна. Мөн японоос оюутан, аспирант судлаачид ирж ажиллаж байна. Өнгөрсөн жил Японы Ерөнхий сайд К.Обучи манай оронд албан ёсны айлчлал хийхдээ япон, монголын харилцааг улам гүнзгийрүүлэн хөгжүүлэхийн тулд соёлын харилцаа, оюутан залуучуудын солилцоо чухал ач холбогдолтойг онцлон тэмдэглэж байлаа. 1998 онд гаргасан Монгол-Японы хэвлэлийн хамтарсан мэдээнд соёл, боловсролын салбар дахь харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх үүднээс гурван жилийн хугацаанд мэргэжил дээшлүүлэгч, оюутан, залуучууд 500 хүнийг сургах боломжтой гэдгээ дурдсан юм. Мөн Японы нэрт зохиолч эмэгтэй Соно Рёоко тэргүүтэй соёлын харилцааны төлөөлөгчид 1999 оны 6-р сард Монголд ирж холбогдох хүмүүстэй уулзан хоёр орны соёлын харилцааны цаашдын төлөв байдлын талаар санал бодлоо солилцсон юм. Энэ бүх үйл ажиллагаа япон судлалд ихээхэн хувь нэмэр оруулах юм.

Өнөөгийн манай япон судлаачдын гол зорилго нь япон судлалын ажлыг улам эрчимжүүлэх, чанаржуулах, Монголын ард түмэнд Японы тусламж дэмжлэгийг зөвөөр сурталчлан ойлгуулах, үнэлэлт дүгнэлт өгөх, Японы эдийн засгийн хөгжил, амжилтанд хүрсэн арга зам, манай орны нөхцөлд авч ашиглаж болох туршлага болон бүс нутгийн хүрээнд хамтран ажиллаж болох боломж зэргийг судлахад оршино. Энэ зорилгоор 1999 онд байгуулагдсан ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнд япон судлалын сектор ажиллаж байна. Мөн япон судлалын ажлыг хийж буй эрдэмтэд, судлаачдыг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж, судалгааны ажлыг сайжруулах санаачлага гарч, 1998 оны эхээр санаачлагчдын хурлыг зохион байгуулж, "Монголын Япон судлаачдын холбоо" нэртэй төрийн бус олон нийтийн байгууллагыг байгуулсан юм. Энэ байгууллагын санаачлагч нь ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төв, Олон улс судлалын төв, МУИС-ын Олон улсын харилцааны дээд сургуулийн япон хэлний тэнхимын багш, судлаач нар юм. Энэ байгууллага нь "Монгол дахь япон судлалын асуудлаар" хэд хэд хуралдсан ба энэхүү хуралд манай улсын судлаачид ба Японы нэрт монголч эрдэмтний нэг профессор Мияваки Жюнко, Японы ЭСЯ-ны ажилтан ноён Варатани нарын судлаач нар оролцсон юм. Япон судлалын ажлыг идэвхтэй хийдэг цаашид энэ чиглэлийн эрдэм шинжилгээний ажил хийх сонирхолтой эрдэмтэд, судлаачид, оюутнууд тус байгууллагад чөлөөтэй нэгдэн ажиллаж болно.

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол дахь Япон судлалын ажлын ирээдүй нь их дээд сургуулиудад зааж байгаа Япон орон судлалын хичээл, япон хэлний хичээлийн чанараас шууд хамааралтай гэдэг нь ойлгомжтой байгаа.